



ГОВЬСҮМБЭР АЙМАГ  
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 04 сарын 30 өдөр

Дугаар А/78

Шивээговь сум

Бэлчээрийн хортон мэрэгчтэй тэмцэх  
ажлыг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3.6, 29.2, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Ургамал хамгааллын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, 10.1.7, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, “Бэлчээр хамгааллын ажлыг эрчимжүүлэх тухай” 185 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2020 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн А/128 дугаар “Бэлчээрийн хортон мэрэгч үлийн цагаан оготнотой тэмцэх ажлыг зохион байгуулах тухай” захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. “Бэлчээр хамгаалах өдөр”-ийг тохиолдуулан бэлчээрт хор хөнөөл учруулж байгаа үлийн цагаан оготнотой тэмцэх ажлыг 2020 оны 04 дүгээр сарын 30-ны өдрөөс 05 дугаар сарын 15-ны өдрийг хүртэлх хугацаанд зохион байгуулсугай.

2. Хортон мэрэгчтэй тэмцэх ажлыг зохион байгуулж, хяналт тавих, мэргэжил арга зүйгээр хангах, гүйцэтгэлийн тайланг холбогдох газруудад хүргүүлэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга:

Б.Баасанбат

(Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Нарийн бичгийн дарга:

Б.Баярцэцэг

(Хөдөө аж ахуйн тасгийн Бэлчээр, газар тариалангийн асуудал хариуцсан мэргэжилтэн)

Гишүүд:

Ш.Буяннэмэх

(Мал эмнэлгийн тасгийн улсын

42120200

байцаагч)

А.Энхмаа

(2 дугаар багийн Засаг даргын  
үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Э.Баярмагнай

(Газрын даамал)

Б.Түвшинжаргал

(Нягтлан бодогч)

О.Отгонбаяр

(Байгаль хамгаалагч)

Д.Эрдэнэтулга

(Хөдөө аж ахуйн тасгийн Хүнс, жижиг  
дунд үйлдвэрлэл, хоршоо хариуцсан  
мэргэжилтэн)

3. Ажил зохион байгуулах төсвийг хавсралтаар баталсугай.

4. Ажлын санхүүжилтийг санхүүгийн хуулийн дагуу зарцуулж, санхүүгийн тайлан мэдээг хугацаанд нь гаргахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч /Б.Түвшинжаргал/-д зөвшөөрсүгэй.


5. Ажлыг хугацаанд нь чанартай зохион байгуулж, нэгдсэн арга зүйгээр хангаж, биелэлтийг тайлагнахыг ажлын хэсгийн дарга /Б.Баасанбат/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



С.ЯГААНЦЭЦЭГ

Сумын Засаг даргын ..... оны .....-р сарын  
.....ны өдрийн ..... дугаар захирамжийн  
хавсралт



### Бэлчээрийн хортон мэрэгчтэй тэмцэх ажлын төсөв

2020.04.30

№	Зарцуулалт	Нийт дүн
1	Томилолтын зардал Ажилчдын хөлсөнд	4,650,000
2	Тээвэр шатахуунд	3,950,000
3	Үйл ажиллагааны зардалд	6,900,000
3	Бүгд	15500000